



**ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО**

ДНБ-ИЙ СУУРИЙГ ШИНЭЧИЛСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2021-07-23

ДНБ-ИЙ СУУРИЙГ ШИНЭЧИЛСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь ДНБ-ий суурь шилжүүлэх тооцоог 2010 оны суурь оноос 2015 оны суурь онд шилжүүлэн тооцлоо. ҮСХ үндэсний тооцооны шинэчлэлтийг 2005, 2010 онд суурь оны нөөц, ашиглалтын хүснэгт (НАХ)-ийг байгуулж, үр дүнд нь үндэслэн ДНБ-ий зэрэгцүүлэх суурь оныг шинэчилж байсан.

Суурь НАХ-ийг 2010 оны гүйцэтгэлээр 2013 онд байгуулж, улмаар НАХ-ийг жилээр байгуулж эхэлсэн. Энэ удаа суурь НАХ-ийг 2015 оны гүйцэтгэлээр байгуулж, өмнөх 2016-2018 оны НАХ-ийг шинэчлэн, 2019 оны гүйцэтгэлээр НАХ-ийг тус тус байгууллаа.

ДНБ-ий суурь шинэчлэх ажил нь ДНБ-ий аргачлал, ангиллыг шинэчлэх, боловсронгуй болгох, мөн хамгийн сүүлийн үеийн мэдээллийг ашиглах боломжийг олгодог давуу талтай. Суурь шинэчлэхтэй холбоотой тусгай судалгаануудыг явуулдаг. Тухайлбал, малын ашиг шимийн гарцын судалгаа, далд эдийн засгийн судалгаа, ААНБ-ын үйл ажиллагааны зардлын судалгаа, салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа гэх мэт. Судалгааны үр дүн болон бусад мэдээлэлд үндэслэн нөөц, ашиглалтын хүснэгтийг суурь оноор шинэчлэн байгуулсан. Энэ нь бодлого боловсруулагч, шинжээчдэд эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг илүү нарийвчлалтай судлах боломжийг олгодог.

ДНБ-ий суурийг 2015 оноор шинэчилснээр зэрэгцүүлэх үнээрх ДНБ-ий өсөлт 2016-2020* онд 0.3-0.8 хувиар, оны үнээрх ДНБ-ий өсөлт -0.1-ээс 1.1 хувиар өөрчлөгдсөн. Ерөнхийдөө ДНБ-ий суурийг шинэчлэх бүрт тодорхой хэмжээний өөрчлөлт гарч байдаг. Өмнө нь ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээс 2010 оны зэрэгцүүлэх үнээр шинэчлэн тооцоход 2011-2013 оны ДНБ-ий өсөлтийн хувь 0.1-0.2 пунктийн өөрчлөлт гарч байсан.

II. ТООЦООНД ОРСОН ТОХИРУУЛГА, ӨӨРЧЛӨЛТ, САЙЖРУУЛАЛТ

ДНБ-ий суурь оныг шинэчлэхийн тулд нөөц, ашиглалтын хүснэгтийг суурь он буюу 2015 оны гүйцэтгэлээр шинэчлэн байгуулсан. Ингэхдээ арга зүйн сайжруулалт, ойлголт тодорхойлолтын өөрчлөлтийг тусгасан. Суурь шинэчлэхэд хийгдсэн гол өөрчлөлтүүд бол хөдөө аж ахуйн салбарын малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын судалгаа, бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийн судалгааны үр дүнгээр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлд өөрчлөлт орсон. Түүнчлэн ҮТС-2008 арга зүйн зөвлөмжийн гол өөрчлөлтийн нэг болох “шууд бусаар хэмжих санхүүгийн байгууллагын үйлчилгээ”-ний арга зүйг банкны салбарын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийн тооцоонд нэвтрүүлсэн. Бараа, үйлчилгээний экспорт, импортын мэдээллийг төлбөрийн тэнцлийн 6-р аргачлалын дагуу тооцоонд тусгасан. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар харуулав.

Суурь нөөц, ашиглалтын хүснэгтийн үр дүнд үндэслэн жилийн нөөц, ашиглалтын хүснэгтийг 2016-2019 оноор байгуулж, ДНБ-ий гүйцэтгэлийг шинэчлэн тооцсон.

III. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

ДНБ-ий тооцоонд арга зүйн болон бусад өөрчлөлтийг тусгаж, суурь шинэчилснээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтийг дараах хэсэгт үзүүлж байна.

Танилцуулгын үндсэн хэсэгт зарим үзүүлэлтүүдийг 2020 оны урьдчилсэн гүйцэтгэлээр харуулсан. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ буюу салбарын нэмэгдэл өртөг болон эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий гүйцэтгэл энэ хугацаанд 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр тооцогдсон, орлогын аргаарх ДНБ, аймаг, нийслэлийн ДНБ-ий хувьд 2020 оны урьдчилсан дүнгээр гараагүй тул 2015-2019 оны гүйцэтгэлийг тусгасан. Үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт хэсгээс авах боломжтой.

3.1. ДНБ, оны үнээр

Шинэчлэгдсэн ДНБ, оны үнээр 2015-2020 онд өмнө нь тархааж байсан ДНБ-ээс (-1.1)-1.5 хувиар өөрчлөгдсөн (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ДНБ, оны үнээр

	Өмнөх (2010 он суурьтай)	Шинэчилсэн (2015 он суурьтай)	Өөрчлөлт
	тэрбум төгрөг		хувь
2015	23 150.4	22 894.8	-1.1
2016	23 942.9	23 931.3	0.0
2017	27 876.3	28 010.7	0.5
2018	32 411.2	32 582.6	0.5
2019	37 280.8	37 839.2	1.5
2020*	36 958.6	37 457.1	1.5

3.2. ДНБ-ий бүтэц

ДНБ-ий салбарын бүтэц

ДНБ-ий суурь оны тооцоо шинэчлэгдсэнээр ДНБ-ий салбарын бүтэц буюу салбаруудын нэмэгдэл өртөг (НӨ)-ийн ДНБ-д эзлэх хувь өөрчлөгдсөн. Хүснэгт 2-т салбаруудын НӨ-ийн ДНБ-д эзлэх хувийг 2015 он болон 2019 оноор харууллаа.

Хүснэгт 2. ДНБ-ий салбарын бүтэц, хувиар

Салбар	2015		2019	
	Өмнөх	Шинэ-чилсэн	Өмнөх	Шинэ-чилсэн
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй	13.3	14.0	10.7	11.5
Уул уурхай, олборлолт	17.6	18.6	23.7	25.8
Үйлдвэрлэл, барилга	16.1	15.6	17.7	15.1
Үйлчилгээ	53.0	51.8	47.9	47.6

Томсгосон салбараар харьцуулбал, суурь шинэчлэгдсэнээр ХАА, уул уурхай, олборлох салбарын НӨ-ийн ДНБ-д эзлэх хувь нэмэгдэж, харин үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын НӨ-ий эзлэх хувь буурсан.

Уг өөрчлөлтийн гол шалтгаан нь суурь судалгааны шинэчилсэн үр дүнг ашиглаж, мэдээллийн эх үүсвэрээ сайжруулсан, салбарын ангилалд орсон өөрчлөлттэй холбоотой. Эдгээр судалгаа болон ангиллын өөрчлөлтийн талаар хавсралтад тусгасан.

ДНБ-ий зардлын бүтэц

ДНБ-ий эцсийн ашиглалтын бүрэлдэхүүний бүтцэд мөн өөрчлөлт орсон. Тухайлбал, өрхийн хэрэглээ, төрийн байгууллагын хэрэглээний зардлын ДНБ-д эзлэх хувь нэмэгдэж, үндсэн хөрөнгийн хуримтлал болон цэвэр экспортын ДНБ-д эзлэх хувь буурсан (хүснэгт 3).

Хүснэгт 3. ДНБ-ий эцсийн ашиглалтын бүрэлдэхүүний бүтэц

Бүрэлдэхүүн	2015		2020*	
	Өмнөх	Шинэ-чилсэн	Өмнөх	Шинэ-чилсэн
	хувь			
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Өрхийн, ӨҮАББ-ын хэрэглээ	59.1	61.9	56.8	58.5
Төрийн байгууллагын хэрэглээ	13.5	14.9	14.6	14.4
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	20.4	18.3	28.3	23.3
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	6.0	6.2	- 4.0	- 0.5
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	1.0	- 1.3	4.4	4.3

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүрэлдэхүүний өөрчлөлтөд бараа, үйлчилгээний цэвэр экспортын өөрчлөлт голлон нөлөөлсөн. Шинэчилсэн тооцоололд бараа, үйлчилгээний экспорт, импортын гүйцэтгэлийг төлбөрийн тэнцлийн 6-р аргачлалын дагуу боловсруулсан мэдээллийг ашигласан, өөрчлөлтийн талаар “Монгол Улсын Төлбөрийн тэнцлийг ОУВС-гийн 6 дугаар аргачлалаар боловсруулах нь” танилцуулгаас харах боломжтой.

ДНБ-ий орлогын бүтэц

ДНБ-ий шинэчлэгдсэн гүйцэтгэлтэй уялдан ДНБ-ий орлогын бүрэлдэхүүний бүтцэд өөрчлөлт орсон (Хүснэгт 4).

Хүснэгт 4. ДНБ-ий орлогын бүрэлдэхүүний бүтэц, хувиар

Бүрэлдэхүүн	2015		2019	
	Өмнөх	Шинэ-чилсэн	Өмнөх	Шинэ-чилсэн
	хувь			
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого	27.0	27.2	26.7	26.5
Үйлдвэрлэлийн татвар	8.5	8.6	11.2	11.0
Үндсэн хөрөнгийн хэрэглээ	8.4	12.9	10.1	10.9
Үйл ажиллагааны орлого/ холимог орлого, цэвэр	56.0	51.2	52.0	51.6

Уг өөрчлөлт нь үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу үндсэн хөрөнгийн элэгдлийн мэдээлэл шинэчлэгдэж, сайжирсантай холбоотой. Энэ зарим томоохон аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдлийн мэдээллээ шинэчилсэнтэй холбоотой. Үндсэн хөрөнгийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь нэмэгдэж, үйл ажиллагааны орлогын ДНБ-д эзлэх хувь буурсан.

¹ [tulburiintentselnewdesc.pdf \(mongolbank.mn\)](http://tulburiintentselnewdesc.pdf(mongolbank.mn))

3.3. ДНБ, зэрэгцүүлэх үнээр

Оны үнээрх ДНБ-ий өөрчлөлт нь эдийн засаг дахь нийт бараа, үйлчилгээний хэмжээнд нөлөөлнө. Эдгээр өөрчлөлт нь үнийн болон биет хэмжээний нөлөөлөл юм. Зэрэгцүүлэх үнийн тооцоонд ашиглаж байгаа индексийн суурь оныг 2010 оноос 2015 онд шилжүүлсэнтэй холбоотой орсон өөрчлөлт нь шинээр бий болгосон үйлдвэрлэгчийн үнийн индексүүдийг ашигласан бөгөөд зарим салбаруудын индекс, дефляторыг бусад тооцоотой уялдуулан шинэчилсэн зэрэг өөрчлөлт юм.

Хүснэгт 5. ДНБ, 2010, 2015 оны зэрэгцүүлэх үнээр


	ДНБ, зэрэгцүүлэх үнээр		ДНБ-ий өсөлт, бууралт	
	2010 оны зэрэгцүүлэх үнээр	2015 оны зэрэгцүүлэх үнээр	Өмнөх	Шинэчилсэн
	тэрбум төгрөг		хувь	
2015	15 850.7	22 894.8		
2016	16 035.9	23 235.9	1.2	1.5
2017	16 891.8	24 545.6	5.3	5.6
2018	18 115.9	26 446.7	7.2	7.7
2019	19 050.5	27 928.3	5.2	5.6
2020*	18 034.0	26 673.8	-5.3	-4.5

3.4. ДНБ-ий өсөлт, бууралт

ДНБ-ий өсөлт, бууралтын хувь

Бодит ДНБ буюу зэрэгцүүлэх үнээрх ДНБ-ий өсөлт, бууралтын өөрчлөлт нь 2016-2020 онд 0.3-аас 0.8 пунктын өөрчлөлттэй байна (Зураг 1).

Зураг 1. ДНБ-ий өсөлт, бууралт, хувиар



Хүснэгт 6. ДНБ-ий өсөлт, бууралт, салбараар, хувиар

Салбар	Өмнөх			Шинэчилсэн		
	2018	2019	2020*	2018	2019	2020*
ДНБ	7.2	5.2	-5.3	7.7	5.6	-4.5
Хөдөө аж ахуй	4.5	8.4	6.2	6.5	5.2	5.8
Уул уурхай, олборлолт	6.1	-0.4	-9.4	5.4	-1.6	-9.1
Боловсруулах үйлдвэрлэл	15.7	10.9	1.3	19.5	3.8	3.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	8.2	5.9	2.4	8.6	7.7	2.6
Усан хангамж	8.2	0.3	-2.3	0.6	0.4	-2.4
Барилга	4.7	8.0	-7.4	1.8	20.3	-7.2
Бөөний болон жижиглэн худалдаа	2.2	7.9	-11.1	0.1	10.9	-11.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	7.6	2.0	-20.1	14.6	4.4	-18.6
Зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны үйлчилгээ	11.6	4.5	-29.7	16.9	9.5	-29.4
Мэдээлэл, холбоо	7.8	7.5	0.4	12.1	12.1	2.7
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	5.5	10.3	0.9	13.7	5.7	3.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6.9	2.6	-1.9	3.1	-2.9	-2.3
Мэргэжлийн, ШУТ-ийн үйл ажиллагаа	7.2	9.2	-0.2	0.5	18.4	-6.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4.0	3.5	-10.6	0.0	9.6	-22.1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	0.6	4.8	0.7	1.6	5.5	1.0
Боловсрол	2.6	3.2	2.3	3.6	6.2	-1.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.6	4.1	1.4	7.0	11.4	1.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.6	4.9	-1.1	2.1	5.0	-1.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.4	-3.6	-3.8	-3.5	-3.6	-4.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	20.1	5.4	-9.8	20.4	9.6	-9.4

ДНБ-ий өсөлт, бууралтад салбаруудын оролцоог авч үзвэл: өмнөх буюу **2010 он суурьтай**-гаар 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр **5.3** хувиар буурсны (-2.0) пункт нь уул уурхай, олборлолтын салбар, (-0.3) пункт нь барилга, (-1.3) пункт нь бөөний болон жижиглэн худалдаа, (-1.5) пункт нь тээврийн салбар, (-0.2) пункт нь үйлчилгээний салбар, (-1.1) пункт нь бүтээгдэхүүний цэвэр татварт тус тус ногдож байсан.

Харин шинэчилсэн буюу **2015 он суурьтай**-гаар 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр **4.5** хувиар буурсны (-1.3) пункт нь уул уурхай, олборлолтын салбар, (-0.3) пункт нь барилга, (-1.3) пункт нь бөөний болон жижиглэн худалдаа, (-1.0) пункт нь тээврийн салбар, (-0.6) пункт нь үйлчилгээний салбар, (-1.1) пункт нь бүтээгдэхүүний цэвэр татварт тус тус ногдож байна (Хавсралт хүснэгт Х4).

ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2020 онд 4.6 хувиар буурсны хөрөнгийн нийт хуримтлал (-38.5) хувь, бараа, үйлчилгээний экспорт (-10.9) хувь, бараа, үйлчилгээний импорт (-20.5) хувиар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий өсөлт, бууралт, хувиар

Бүрэлдэхүүн	Өмнөх			Шинэчилсэн		
	2018	2019	2020*	2018	2019	2020*
ДНБ	7.0	5.0	-5.4	7.6	5.5	-4.6
Эцсийн хэрэглээ	10.1	10.5	5.1	9.6	7.0	2.2
Өрхийн аж ахуйн хэрэглээ	12.4	9.9	2.7	11.7	5.8	0.5
Төрийн байгууллагын хэрэглээ	0.5	13.6	16.0	1.1	12.3	9.5
Хөрөнгийн нийт хуримтлал	18.6	30.5	-42.5	52.1	0.2	-38.5
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	21.3	23.5	-11.8	31.8	14.0	-20.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	8.6	58.9	-	131.6	-	-
Цэвэр экспорт	-	-	-	-	-	-
Бараа, үйлчилгээний экспорт	24.0	9.1	-0.1	6.1	12.0	-10.9
Барааны экспорт	25.3	9.1	4.4	5.2	11.9	-4.7
Үйлчилгээний экспорт	14.2	9.2	-39.1	10.5	12.6	-40.6
Бараа, үйлчилгээний импорт	30.9	22.3	-8.9	32.7	8.6	-20.5
Барааны импорт	40.6	14.0	1.2	28.0	7.1	-11.4
Үйлчилгээний импорт	10.5	44.3	-30.1	40.7	11.0	-34.1

ДНБ-ий өсөлт, бууралтад бүрэлдэхүүний оролцоог авч үзвэл: өмнөх буюу **2010 он суурьтай**-гаар 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр **5.4** хувиар буурсны (3.8) пункт нь эцсийн хэрэглээ, (-19.3) пункт нь хөрөнгийн нийт хуримтлал, (-0.1) пункт нь бараа, үйлчилгээний экспорт, (-10.2) пункт нь бараа, үйлчилгээний импортод тус тус ногдож байгаа бол шинэчилсэн буюу **2015 он суурьтай**-гаар 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр **4.6** хувиар буурсны (1.8) пункт нь эцсийн хэрэглээ, (-15.3) пункт нь хөрөнгийн нийт хуримтлал, (-5.6) пункт нь бараа үйлчилгээний экспорт, (-14.5) пункт нь бараа, үйлчилгээний импортод тус тус ногдож байна (Хавсралт хүснэгт Х7).

3.5. Бүс нутгийн ДНБ, оны үнээр

Хүснэгт 8. ДНБ, бүс, аймаг, нийслэлээр, 2015 он

	Өмнөх				Шинэчилсэн				Өөрчлөлт
	ДНБ, тэрбум төг	ХАА	Үйлд-вэрлэл	Үйлчил-гээ	ДНБ, тэрбум төг	ХАА	Үйлд-вэрлэл	Үйлчил-гээ	
									дүнд эзлэх хувь
ДНБ	23 150.4	13.3	33.7	53.1	22 894.8	14.0	34.2	51.8	(1.1)
Баруун бүс	1 511.1	43.8	16.6	39.6	1 508.9	49.0	12.6	38.4	(0.1)
Баян-Өлгий	311.0	40.7	13.8	45.5	325.4	45.2	12.9	41.9	4.6
Говь-Алтай	237.1	47.0	19.3	33.6	232.0	55.1	11.1	33.8	(2.2)
Завхан	310.6	46.8	11.8	41.4	322.1	48.9	12.3	38.8	3.7
Увс	330.1	41.3	21.0	37.8	314.1	47.4	14.2	38.4	(4.8)
Ховд	322.3	44.1	17.6	38.4	315.2	50.1	12.2	37.7	(2.2)
Хангайн бүс	3 053.9	33.9	41.4	24.7	3 100.1	36.0	39.9	24.1	1.5
Архангай	417.3	60.6	16.8	22.6	436.0	62.4	16.4	21.3	4.5
Баянхонгор	366.1	47.3	22.3	30.4	337.3	54.1	12.4	33.5	(7.9)
Булган	301.4	59.3	17.4	23.3	302.6	60.1	17.0	22.9	0.4
Орхон	1 053.2	1.2	81.5	17.4	1 130.7	1.1	82.8	16.2	7.4
Өвөрхангай	409.5	50.4	17.1	32.6	423.7	53.5	14.6	31.9	3.5
Хөвсгөл	506.3	41.8	25.9	32.3	469.8	51.0	16.1	32.9	(7.2)
Төвийн бүс	2 348.2	35.1	29.4	35.5	2 335.1	35.5	26.0	38.5	(0.6)
Говьсүмбэр	83.7	25.8	30.7	43.5	86.6	23.9	30.3	45.7	3.5
Дархан-Уул	367.3	9.8	40.9	49.2	364.3	9.5	36.5	54.0	(0.8)
Дорноговь	261.3	36.0	8.0	56.0	308.9	32.2	9.1	58.7	18.2
Дундговь	237.6	60.1	11.9	28.0	242.4	58.8	14.0	27.2	2.0
Өмнөговь	281.3	32.8	20.9	46.3	286.0	34.1	20.3	45.6	1.7
Сэлэнгэ	574.5	25.0	47.7	27.2	535.4	25.9	43.6	30.5	(6.8)
Төв	542.6	54.0	24.4	21.6	511.5	57.9	18.5	23.6	(5.7)
Зүүн бүс	1 272.4	35.9	40.9	23.2	1 246.5	35.4	41.5	23.1	(2.0)
Дорнод	597.7	17.1	61.7	21.2	592.6	17.8	62.0	20.3	(0.9)
Сүхбаатар	326.9	46.2	32.1	21.7	319.9	45.7	32.4	21.9	(2.1)
Хэнтий	347.8	58.6	13.2	28.2	334.0	56.9	13.9	29.2	(4.0)
Улаанбаатар	14 964.7	0.6	33.9	65.5	14 704.1	0.6	35.8	63.6	(1.7)

ДНБ-ий суурь шинэчлэгдсэнээр 2015 оны гүйцэтгэлд 1.1 хувийн бууралт гарсан бөгөөд бүс нутгаар харьцуулбал, хангайн бүс 1.5 хувь өссөн, бусад бүсийнх 0.1-2.0 хувиар буурчээ.

Аймгаар харьцуулбал, Баян-Өлгий (4.6%), Завхан (3.7%), Архангай (4.5%), Өвөрхангай (3.5%), Дорноговь (18.2%), Дундговь (2.0%), Говьсүмбэр (3.5%), Өмнөговь (2.0%), Орхон (7.4%), Булган (0.4%) тус тус өсөж, харин бусад аймгийнх 0.8-7.9 хувиар буурчээ.

Эдгээр өөрчлөлтөд ХАА-н салбарын суурь судалгаануудын үр дүн болон бичил уурхай эрхлэгчдийн судалгааны үр дүн² голлон нөлөөлсөн. Судалгааны үр дүнгийн талаар хавсралт хэсэгт тусгасан.

² sam.mn/бичил-уурхай-эрхлэгчдийн-судалгааны-нэгдсэн-тайлан-2016/

3.6. Макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүд

Үндэсний нийт орлого


Үндэсний нийт орлого гэдэг нь хаана үйлдвэрлэгдсэнээс нь шалтгаалахгүйгээр тухайн улсын эдийн засгийн харьяатуудын эзэмшиж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн орлогын нийлбэр үзүүлэлт юм. ҮНО-ыг ДНБ болон гадаад эдийн засгаас орсон цэвэр анхдагч орлогын нийлбэрээр тооцно.

Хүснэгт 9. ҮНО, оны болон зэрэгцүүлэх үнээр

	Өмнөх		Шинэчилсэн	
	Оны үнээр	2010 оны үнээр	Оны үнээр	2015 оны үнээр
2015	21 251.4	14 550.5	20 988.6	20 988.6
2016	21 971.1	14 837.2	21 959.6	21 321.4
2017	23 951.4	14 647.2	24 085.8	21 106.2
2018	29 089.3	16 377.4	29 530.5	23 969.3
2019	33 093.8	16 910.9	33 652.1	24 837.9
2020*	33 395.7	16 226.1	33 912.5	24 149.6

тэрбум төгрөг

Зураг 2. ДНБ, ҮНО, нэг хүнд ногдох ДНБ, ҮНО-ын жилийн өөрчлөлт (оны үнээр)



Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн хэмжээ

Хүснэгт 10. Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь

	Өмнөх	Шинэчилсэн
2015	80.0	79.1
2016	79.1	78.5
2017	76.7	75.5
2018	77.1	76.0
2019	74.7	74.5

Хувийн хэвшилд бүтээгдсэн НӨ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015-2019 онд 0.2-1.3 пунктээр буурсан.

Энэ нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал салбарт үндсэн хөрөнгийн хэрэглээг нөхөж тооцсонтой холбоотой уг салбарын НӨ нэмэгдснээр төрийн өмчийн ААНБ-ын НӨ-ийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн.

Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

Хүснэгт 11. Нэг хүнд ногдох ДНБ


	2015	2016	2017	2018	2019	2020*
	Өмнөх					
Нэг хүнд ногдох ДНБ, мянган төгрөг	7 810.3	7 910.0	8 999.2	10 259.8	11 680.6	11 459.5
Нэг хүнд ногдох ДНБ ¹ , америк доллар, Дэлхийн Банкны атласын аргаар	4 218	3 854	3 780	4 050	4 317	4 167
Нэг хүнд ногдох ҮНО, мянган төгрөг	7 020.9	7 113.0	7 606.2	9 067.2	10 127.6	10 114.0
Нэг хүнд ногдох ҮНО, америк доллар, Дэлхийн Банкны атласын аргаар	3 791	3 465	3 195	3 579	3 743	3 678
	Шинэчилсэн					
Нэг хүнд ногдох ДНБ, мянган төгрөг	7 724.1	7 906.2	9 042.5	10 314.1	11 855.6	11 614.1
Нэг хүнд ногдох ДНБ ² , америк доллар	3 920	3 681	3 705	4 171	4 450	4 128
Нэг хүнд ногдох ҮНО, мянган төгрөг	6 934.1	7 109.3	7 648.9	9 204.7	10 298.5	10 192.5
Нэг хүнд ногдох ҮНО, америк доллар, Дэлхийн Банкны атласын аргаар	3 739	3 449	3 196	3 644	3 798	3 690

Нэг ажиллагчид ногдох ДНБ (хөдөлмөрийн бүтээмж)

Хүснэгт 12. Нэг ажиллагчид ногдох ДНБ

	Өмнөх (2010 оны зэрэгцүүлэх үнээр)		Шинэчилсэн (2015 оны зэрэгцүүлэх үнээр)	
	мянган төгрөг	Өмнөх он=100, %	мянган төгрөг	Өмнөх он=100, %
2015	13 099.3		18 633.8	
2016	13 281.2	101.4	18 980.5	101.9
2017	13 011.5	98.0	18 517.6	97.6
2018	13 751.5	105.7	19 759.3	106.7
2019	15 824.7	115.1	22 980.7	116.3
2020*	15 137.4	95.7	21 594.7	94.0

**Зураг 3. Нэг хүнд ногдох ДНБ, нэг ажиллагчид ногдох ДНБ
(2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг)**



Хавсралт

Арга зүйтэй холбоотой өөрчлөлт:

ҮТС-2008 зөвлөмжид орсон гол өөрчлөлтийн нэг бол “шууд бусаар хэмжих санхүүгийн байгууллагын үйлчилгээ” юм. “Санхүүгийн зуучлагчид нь мөнгө зээлэхдээ доогуур хүү төлж, мөнгө зээлдүүлэхдээ өндөр хүү авдаг. Зээлдүүлэгчдэд төлөх, зээлдэгчдээс авах хүүгийн хэмжээ харилцан адилгүй байдгаас үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг шууд тодорхойлох боломжгүй. Санхүүгийн зуучлагчид нь хүүгийн цэвэр орлогоор үйл ажиллагаагаа санхүүжүүлж, үлдсэн нь үйл ажиллагааны ашиг болно. Үүнийг ҮТС-д тодорхой төлбөргүй үзүүлсэн үйлчилгээний өртөг буюу шууд бусаар хэмжих санхүүгийн зуучлалын үйлчилгээ гэсэн шууд бус хэмжигдэхүүнийг ашиглан тооцдог.

Өмнөх тооцоонд банк, зээлийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйлдвэрлэлийг тооцохдоо банкны системийн байгууллагад бусад байгууллага, иргэдээс зээлийн хүүд төлсөн төлбөр болон банкны системийн байгууллагаас бусдад төлсөн хүүгийн зөрүү хүүгийн цэвэр орлогоор тооцдог байсан.

Шинэчилсэн тооцоонд банк, зээлийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйлдвэрлэлийг тооцохдоо олгосон нийт зээл болон хадгаламжийн хэмжээнд суурилсан шууд бусаар хэмжих санхүүгийн байгууллагын үйлчилгээний нийлбэр дүнгээр тодорхойлж байна.

Шинэ арга зүйг нэвтрүүлснээр санхүүгийн салбарын нэмэгдэл өртөг 2015-2019 онд 240.7-416.4 тэрбум төгрөг буурах нөлөөллийг үзүүлсэн .


Ангилалтай холбоотой өөрчлөлт:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангилал (ЭЗҮАСА 4.0)-ыг Сангийн сайд, ҮСХ-ны дарга нарын хамтарсан тушаалаар 2018 онд шинэчлэн баталсан.

Шинэчилсэн тооцоонд ангилалтай холбоотой хэд хэдэн өөрчлөлт орсон. Үүнд:

Мал аж ахуйн салбарт хамрагдаж байсан *арьс ширний үйлдвэрлэлийн* тооцоог “Хөдөө аж ахуй”-н салбар”-аас “Боловсруулах үйлдвэрлэл”-ийн “мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл” салбар (1010)-т; “Боловсруулах үйлдвэрлэл”-ийн “Кокс болон боловсруулсан нефтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл” салбарт орж байсан *угаасан нүүрс болон коксжих нүүрсний үйлдвэрлэлийг* нүүрс олборлолтын салбарт; Урлаг, үзвэр, тоглоом салбарт орж байсан кино үзвэрийн үйл ажиллагааг мэдээлэл, холбооны салбарт тус тус шилжүүлж тооцсон (Зураг 4).

Зураг Н1. Үйл ажиллагааны салбарын ангилалд орсон өөрчлөлт



Дээрх өөрчлөлтөөс гадна суурь шинэчлэх ажлын хүрээнд тооцоонд хамрагдсан ААНБ-ын үйл ажиллагааны чиглэлийг нягтлан сайжруулах чиглэлээр ажилласан.

Тооллого, судалгааны шинэчилсэн үр дүн буюу мэдээллийн эх үүсвэр сайжирсантай холбоотой өөрчлөлт:

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

ХАА-н салбарын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийг 2015 оны суурьт шилжүүлэхэд дараах суурь судалгаануудын үр дүнг ашиглан, тооцооллыг шинэчлэн хийсэн.

- Малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын түүвэр судалгаа
- ХАА-н салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа
- ХАА-н салбарын өртөг, зардлын судалгаа


Малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын түүвэр судалгаагаар малын сүүний гарц, саалинд хамрагдсан малын хувь, ноос, ноолуурын гарц гэсэн үзүүлэлтийн үр дүнг аймаг, бүсээр шинэчлэн тогтоосон.

Үйлдвэрлэгчийн үнийн индексийг салбар бүрт шинээр бий болгох ажил сүүлийн жилүүдэд хийгдэж байна. Уг ажлын хүрээнд “ХАА-н үйлдвэрлэгчийн үнийн судалгаа 2015” суурь судалгааны үр дүнгээр газар тариалан, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс улсын дүн болон бүсээр тооцогдсон.

ХАА-н салбарын өртөг, зардлын суурь судалгааг газар тариалан болон мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг өрхүүдэд 2015 оны байдлаар явуулж үр дүнг шинэчилсэн.

Улсын хэмжээнд мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл шинэчлэгдсэн суурь судалгааны үр дүнгээр 2015-2019 онд 9.7-13.8 хувиар нэмэгдсэн байна (Зураг Х1). Уг өөрчлөлтийг задлаж харвал, ерөнхийдөө малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарц буурч, харин бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн байна. Тухайлбал 2015 онд мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл 13.8 хувиар өсөхөд ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын хэмжээ 7.0 хувиар буурч, бүтээгдэхүүний үнэ 20.8 хувиар нэмэгдсэн байна.

Зураг Н2. МАА-н салбарын оны үнээрх нийт үйлдвэрлэлийн өөрчлөлт, хувиар



Судалгааны үр дүнг бүсээр авч үзвэл:

Баруун бүс: Баруун бүсийн газар тариалангийн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 30.0 тэрбум төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос -2.1 тэрбум төгрөгөөр буурлаа. Уг бууралтад манжин, сонгино, төмс зэрэг хүнсний ногооны үйлдвэрлэгчийн үнэ 13.5-26.7 хувь, тосны ургамлын үйлдвэрлэгчийн үнэ 13.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Баруун бүсийн мал аж ахуйн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 706.8 тэрбум төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос 80.3 тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, малын ашиг шимийн гарцын судалгааны үр дүн голлон нөлөөлсөн.

Үйлдвэрлэгчийн үнийн судалгааны 2015 оны үр дүнг 2010 суурьтайгаар тооцсон 2015 оны үр дүнтэй харьцуулбал, малын үнэ 1.1-85.9 хувь, сүүний үнэ 17.9-32.1 хувь, ноос, ноолуурын үнэ 6.6-53.8 хувиар өссөн нь мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг өсөхөд голлон нөлөөлсөн.

Харин малын сүүний гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг ингэний сүүний жилийн дундаж гарц 18.0 литр, гүүний сүүний гарц 105.9 литр, үнээний сүүний гарц 114.6 литр, хонины сүүний гарц 6.5 литр, ямааны сүүний гарц 12.5 литрээр тус тус буурсан байна.

Малын ноос, ноолуурын гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг ямааны ноолуурын жилийн дундаж гарц 47.9 грамм, хонины ноос 75.0 грамм, бодын хөөвөр, хялгас 16.8-102.0 граммаар тус тус буурсан байна.

Хангайн бүс: Хангайн бүсийн газар тариалангийн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 39.3 тэрбум төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос -5.1 тэрбум төгрөгөөр буурлаа. Уг бууралтад лууван, манжин, сонгино, төмс зэрэг хүнсний ногооны үйлдвэрлэгчийн үнэ 3.2-43.3 хувь, задгай өвсний үйлдвэрлэгчийн үнэ 16.7 хувь, тосны ургамлын үйлдвэрлэгчийн үнэ 2.0 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хангайн бүсийн мал аж ахуйн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 1.1 их наяд төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос 85.8 тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, малын ашиг шимийн гарцын судалгааны үр дүн голлон нөлөөлсөн.

Үйлдвэрлэгчийн үнийн судалгааны 2015 оны үр дүнг 2010 суурьтайгаар тооцсон 2015 оны үр дүнтэй харьцуулбал, малын үнэ 0.3-86.6 хувь, сүүний үнэ 9.0-89.9 хувь, ноос, ноолуурын үнэ 28.1-63.2 хувиар өссөн нь мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг өсөхөд голлон нөлөөлсөн.

Харин хангайн бүсийн малын сүүний гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг ингэний сүүний жилийн дундаж гарц 28.2 литр, гүүний сүүний гарц 20.5 литр, үнээний сүүний гарц 151.8 литр, хонины сүүний гарц 1.1 литр, ямааны сүүний гарц 3.1 литрээр тус тус буурсан байна.

Малын ноос, ноолуурын гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг ямааны ноолуурын жилийн дундаж гарц 19.1 грамм, хонины ноос 74.0 грамм, бодын хөөвөр, хялгас 39.4-121.1 граммаар тус тус буурсан байна.

Төвийн бүс: Төвийн бүсийн газар тариалангийн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 84.2 тэрбум төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос -12.1 тэрбум төгрөгөөр буурлаа. Уг бууралтад байцаа, манжин, сонгино, төмс зэрэг хүнсний ногооны үйлдвэрлэгчийн үнэ 8.4-46.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Төвийн бүсийн мал аж ахуйн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 743.6 тэрбум төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос 20.0 тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, малын ашиг шимийн гарцын судалгааны үр дүн голлон нөлөөлсөн.

Үйлдвэрлэгчийн үнийн судалгааны 2015 оны үр дүнг 2010 суурьтайгаар тооцсон 2015 оны үр дүнтэй харьцуулбал, малын үнэ 2.7-60.0 хувь, сүүний үнэ 23.9-27.2 хувь, ноос, ноолуурын үнэ 16.5-68.5 хувиар өссөн нь мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг өсөхөд голлон нөлөөлсөн.

Харин төвийн бүсийн малын сүүний гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг гүүний сүүний жилийн дундаж гарц 57.6 литр, үнээний сүүний гарц 158.2 литр, хонины сүүний гарц 9.3 литр, ямааны сүүний гарц 5.0 литрээр тус тус буурсан байна.

Малын ноос, ноолуурын гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг ямааны ноолуурын жилийн дундаж гарц 113.2 грамм, бодын хялгас 57.8 граммаар буурсан бол хонины ноос 42.0 граммаар тус тус өссөн байна.

Зүүн бүс: Зүүн бүсийн газар тариалангийн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 25.6 тэрбум төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос 3.4 тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд сонгино, манжин, лууван, байцаа зэрэг хүнсний ногооны үйлдвэрлэгчийн үнэ 28.2-91.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зүүн бүсийн мал аж ахуйн салбарын 2015 оны нэмэгдэл өртөг 2015 суурьтай тооцоогоор 415.5 тэрбум төгрөг болж, 2010 суурьтай тооцооноос 18.2 тэрбум төгрөгөөр буурлаа. Уг бууралтад үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, малын ашиг шимийн гарцын судалгааны үр дүн голлон нөлөөлсөн.

Үйлдвэрлэгчийн үнийн судалгааны 2015 оны үр дүнг 2010 суурьтайгаар тооцсон 2015 оны үр дүнтэй харьцуулбал, сүүний үнэ 11.2-69.2 хувь, ноос, ноолуурын үнэ 36.7-57.6 хувиар өссөн ч малын үнэ 5.5-27.2 хувиар буурсан нь мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг буурахад голлон нөлөөлсөн.

Харин зүүн бүсийн малын сүүний гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг гүүний сүүний жилийн дундаж гарц 104.9 литр, үнээний сүүний гарц 67.2 литр, хонины сүүний гарц 3.2 литрээр тус тус буурсан байна.

Малын ноос, ноолуурын гарцын судалгааны 2015 оны үр дүнг 2010 онтой харьцуулбал, нэг ямааны ноолуурын жилийн дундаж гарц 69.4 грамм, хонины ноос 166.0 грамм, бодын хялгас 70.5 граммаар тус тус буурсан байна.

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТЫН САЛБАР

Уул уурхай, олборлолтын салбарын албан бус секторын үйлдвэрлэлийг 5 жил тутам явагддаг “Бичил уурхай эрхлэгчдийн судалгаа”-г ашиглан тооцдог. Энэ удаагийн тооцоонд 2016 оны бичил уурхай эрхлэгчдийн судалгааны үр дүнг ашигласан.

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгааны дүнгээр нийт 12.0 мянган иргэн бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байна. Өмнөх суурь судалгаа нь 2012 онд явагдсан. Судалгааны үр дүнг харьцуулбал, 2016 оны суурь судалгааны дүнгээр улсын хэмжээнд бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо 6.0 мянгад хүрч, өмнөх судалгааны үеэс 17.5 хувиар, олборлосон алтны хэмжээ 40.2 хувиар тус тус буурсан байна (Хүснэгт Н1).

Хүснэгт Н1. Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бүсээр, 2012 он, 2016 он

	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо			Алт олборлогчдын тоо			Олборлосон алт, кг		
	2012	2016	%	2012	2016	%	2012	2016	%
Бүгд	7 273	5 998	82.5	10 458	5 108	48.8	354.6	212.0	59.8
Баруун	1 982	2 527	127.5	2 946	2 274	77.2	71.7	62.5	87.2
Хангайн	2 183	935	42.8	3 899	963	24.7	139.6	48.9	35.0
Төвийн	2 236	2 202	98.5	3 557	1 721	48.4	141.9	97.1	68.4
Зүүн	251	164	65.3	56	56	100.0	1.4	0.9	60.7
Улаанбаатар	621	170	27.4	-	94	-	-	2.7	-

Бичил уурхай эрхлэгчдийн тоо хангай бүс дэх аймгуудад дунджаар 57.2 хувь, зүүн бүсийн аймгуудад 34.7 хувиар тус тус буурсан байна. Энэ нь аймгийн ДНБ-ий гүйцэтгэлд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт уламжлалт аргаар бэлтгэсэн мах, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тооцоог дараах ХАА-н суурь судалгаануудын үр дүнгээр шинэчлэн тооцсон.

- Малын ашиг, шимийн түүвэр судалгаа
- ХАА-н салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хувийн буюу өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийн тооцоо нь ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоонд үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт, ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцоонд өрхийн эцсийн хэрэглээнд, ДНБ-ий орлогын аргын тооцоонд үйл ажиллагааны ашигт тус тус тусгагддаг.

Өмнөх тооцоонд Хувийн орон сууцны хийсвэр түрээсийн зардлын “Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөр 2011”-гийн хүрээнд хийгдсэн орон сууцны түрээсийн үнийн судалгааны *улсын дундаж үнийг* ашиглаж байсан.

Шинэчилсэн тооцоонд “Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөр 2017”-гийн хүрээнд хийгдсэн орон сууцны түрээсийн үнийн судалгааны *бүсийн дундаж үнийг* ашиглан тооцсон.

ТӨРИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сангийн яам улсын чанартай зам гүүрийн байгууламжид үндсэн хөрөнгийн элэгдлийг шинэчлэн тооцсон. Үндэсний тооцоонд уг үзүүлэлтийг үндсэн хөрөнгийн хэрэглээ гэж үздэг, ДНБ-ий 2015-2019 оны гүйцэтгэлд үндсэн хөрөнгийн хэрэглээ 272.7-443.9 тэрбум төгрөг нэмэгдэж тусгагдсан. Энэ нь ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоонд төрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааны салбарт, ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцоонд төрийн байгууллагын эцсийн хэрэглээнд, ДНБ-ий орлогын аргын тооцоонд үндсэн хөрөнгийн хэрэглээнд тус тус тусгагддаг.

